



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/95

Шивээговь сум

“Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-т нүүрс тээвэрлэх автомашин худалдан авах” ажлыг хүлээж авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Сумын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авч буй “Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-т нүүрс тээвэрлэх автомашин худалдан авах” ажлыг хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

- |                       |                                                                                                                                                                                                      |
|-----------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Комиссын дарга:       | Д.Отгонжаргал<br>(Засаг даргын Тамгын газрын дарга)                                                                                                                                                  |
| Гишүүд:               | Ш.Чинболд<br>(Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-ын захирал)<br>Б.Мөнхдорж<br>(Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-ын ХАБЭА-н инженер)<br>Х.Мөнхжаргал<br>(Шивээ Овоо хувьцаат компанийн Автобульдозерийн хэсгийн цахилгаанчин) |
| Нарийн бичгийн дарга: | Б.Алтансүх<br>(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)                                                                                               |

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авч буй “Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-т нүүрс тээвэрлэх автомашин худалдан авах” ажлыг хүлээн авч ашиглалтад оруулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг комиссын дарга (Д.Отгонжаргал)-д, өмч хөрөнгийг

бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн (Б.Алтансүх)-д, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, үр ашгийг дээшлүүлэн ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-ын захирал (Ш.Чинболд) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ